



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/201

Мандалговь

Г Ажлын хэсэг томилох тухай 7

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 12.1, Сангийн сайдын 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар" журмын 6.5 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд :

- | | |
|------------------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч : | Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга : | ХОХБТХ-ийн эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан ерөнхий эдийн засагч |
| Гишүүд : | ХОХБТХ-ийн дарга |
| | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | Хууль эрхзүйн хэлтсийн дарга |
| | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| | Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга |
| | Б.Гантогтох (ИТХ-ийн төлөөлөгч) |
| | Б.Ням (МУХАҮТ-ын Дундговь аймаг дахь салбар танхимын дарга) |

Хоёр. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан олон нийтийн эрх ашигт нийцсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, холбогдох журмын шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган танилцуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200800